



# ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Дорноговь аймгийн  
нийгэм, эдийн засгийн  
танилцуулга

## ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

# 2019/09



Мэдээллийн нэгдсэн лавлах: [WWW.1212.MN](http://WWW.1212.MN)

## ГАРЧИГ

Товч танилцуулга.....	1-14
Нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд.....	15
Нэг. Эрүүл мэнд.....	16-17
Хоёр. Соёл, боловсрол .....	18
Гурав. Хөдөлмөр эрхлэлт .....	19-21
Дөрөв. Нийгмийн даатгал, халамж.....	22-25
Тав. Гэмт хэрэг.....	26-27
Зургаа. Төсөв, санхүү .....	28-29
Долоо. Үнэ .....	31-34
Найм. Хөдөө аж ахуй.....	35-37
Ес. Аж үйлдвэр .....	38-42
Арав. Тээвэр.....	43
Арван нэг. Байгаль орчин .....	44

## ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

( 2019 оны 09 дүгээр сарын байдлаар)

### Нэг. Нийгмийн үзүүлэлт




#### 1.1 Хүн ам

Дорноговь аймгийн хэмжээнд 2019 оны 09 сард 970 эх амаржиж, 975 хүүхэд шинээр мэндэлж, 290 хүн нас барсан байна. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 64(6.2%)-өөр, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 62(6.0%)-аар, нас барсан хүний тоо өмнөх оны мөн үеэс 8(2.7%)-аар тус тус буурчээ.

Хүн амын цэвэр өсөлт 685 болж 2018 оны мөн үеийнхээс 54(7.3%)-аар буурсан байна. 1000 хүнд ногдох төрөлт 14.2, нас баралт 4.2 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 1.2 пунктээр, нас баралт 0.2 пунктээр тус тус буурсан байна.

Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2016-2019 оны 09 сард



Он гарсаар эхийн эндэгдэл гараагүй бөгөөд нялхсын эндэгдэл 7 байна.



#### 1.2 Эрүүл мэнд


2019 оны 09 сарын байдлаар 300.0 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 13.9 хувиар, 10.5 мянган хүн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 25.0 хувиар, 12.6 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 0.8 хувиар тус тус өссөн байна.

2019 оны 09 сард 1417 эх жирэмсний хяналтанд орсны 88.9 хувь буюу 1260 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ. Жирэмсний хяналтанд хугацаандаа орсон эхийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.9 пунктээр өссөн байна.

Түргэн тусламжийн дуудлага 14.7 мянган удаа гарсны 2.5 мянга буюу 17.0 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага өмнөх оны мөн үеэс 0.7 хувиар өсч, алсын дуудлага өмнөх оны мөн үетэй адил хэмжээнд байна.

Он гарсаар ослын улмаас 2496 хүн бэртэж, 60 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэртэж гэмтсэн хүний тоо 90(3.7%)-ээр өсч, нас барсан хүний тоо 16(21.1%)-аар тус тус буурчээ.

Зураг. Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2019 оны 09 сард



Нас баралтыг өвчний шалтгаанаар авч үзэхэд цусны эргэлтийн тогтолцооны өвчин 25.2 хувь, хавдар 24.5 хувь, осол, гэмтэл хордлого гадны шалтгаант үхэл 20.7 хувь, бусад төрлийн өвчин 15.2 хувь, амьсгалын тогтолцооны өвчин 7.6 хувь, хоол шингээх эрхтний өвчин 6.9 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт өвчний 772 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 239-өөр буюу 44.8 хувиар өсчээ. Халдварт өвчний тохиолдол өсөхөд тэмбүү 60.7 хувиар, заг хүйтэн 55.8 хувиар, трихоминиаз 95.5 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

### 1.3 Соёл

Аймгийн соёл урлагын байгууллагууд эхний 9 сарын байдлаар 29.5 мянган хүнд үйлчилж, 46.7 сая төгрөгийн орлоготой ажиллажээ. Аймагт үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн урлагийн байгууллага 66 удаагийн тоглолт хийж, музейнүүд дотоод, гадаадын 4.5 мянган хүнд үйлчилсэн байна.

2019/2020 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийг бага, суурь, бүрэн дунд боловсролоор 3645 суралцагч элсэн суралцаж байгаа нь өмнөх оны мөн үеэс 94(2.6%)-өөр өссөн байна. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Төмөр замын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, ЭМШУИС-ийн салбар сургуулийг 650 оюутан суралцагч элсэн суралцаж байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 6(0.9%)-аар буурчээ.




### 1.4 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2019 оны 09 сарын эцэст 470 болсны 458(97.5%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 12(2.5%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 495(51.3%) хүнээр, өмнөх сараас 118(20.1%) хүнээр тус тус буурчээ.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн боловсролын түвшинг харахад 349(74.3%) нь бүрэн дунд, 56(11.9%) нь дээд, 28(6.0%) нь бүрэн бус дунд, 12(2.6%) нь техник болон мэргэжлийн, 10(2.1%) нь тусгай дунд, 2(0.4%) нь бага, 1(0.2%) нь магистр, 12(2.6%) нь боловсролгүй иргэд эзэлж байна.


Зураг. Ажилгүй иргэдийн тоо, боловсролоор, хувиар, 2019 оны 09 сарын эцэст



Хөдөлмөрийн хэлтэст 2019 оны 09 сарын эцэст 131 иргэн шинэ ажлын байранд орж, бүртгэлтэй байсан 368 иргэн ажилд зуучлагдан орж, 193 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна.

Хөдөлмөрийн хэлтэст ирсэн 397 ажлын байрны 135(34.0%) нь энгийн ажил, 58(14.6%) нь техникч болон туслах / дэд мэргэжилтэн, 55 (13.9%) нь мэргэжилтэн, 42(10.6%) нь суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, 30(7.6%) нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан, 25(6.3%) нь контор үйлчилгээний ажилтан, 22(5.5%) нь худалдаа, үйлчилгээний ажилтан, 15(3.8%) нь ХАА, ой, загас агнуурын ажилтан, 15(3.8%) бусад салбарын ажлын байрны захиалга байна.

Зураг. Бүртгэлгүй ажилгүй иргэд сумаар






### 1.5 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2019 оны эхний 9 сарын байдлаар 30579.7 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 6780.6 (28.5%) сая төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 2019 оны 9 сард өмнөх оны мөн үеэс 6780.6 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгал 4341.3 (29.0%) сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгал 715.5 (28.8%) сая төгрөг тэтгэмжийн даатгал 491.2 (28.9%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгал 196.9 (28.6%) сая төгрөгөөр өссөн байна.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2019 оны 09 сард



Нийгмийн даатгалын сангийн зарлага 37807.1 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 4503.4 (13.5%) сая.төгөөр өссөн байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 27992.6 (74.0%) сая.төг, эрүүл мэндийн даатгалын сангаас 4482.1 (11.9%) сая.төг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 2240.2 (5.9%) сая.төг, тэтгэмжийн даатгалын сангаас 2268.1 (6.0%) сая.төг, ажилгүйдлийн даатгалын сангаас 824.1 (2.2%) сая төгрөгийг зарцуулжээ.


Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сая төг




Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2019 оны 09 сард нийгмийн халамжийн сангаас 24218 иргэнд 6327.8 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад халамж авсан иргэд 1220(5.3%)-оор өсч, олгосон тэтгэвэр тэтгэмж 257.8(4.2%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2019 оны 09 сард 1394 хүн хамрагдсан нь өмнөх оноос 32(2.3%)-ээр өсч, олгосон тэтгэвэрийн хэмжээ 217.5(12.8%) сая төгрөгөөр нэмэгджээ. Нийгмийн нөхцөлт мөнгөн тусламжийг 1063 иргэнд 628.5 сая төгрөг, онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг 963 иргэнд 452.0 сая төгрөг тус тус олгож, нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургахад 9284 иргэнийг хамруулж, 813.6 сая төгрөгийг зарцуулсан байна. Бусад төрлийн халамжийн үйлчилгээнд 11514 иргэн хамрагдаж, 2515.9 сая төгрөгийг олгожээ.

Зураг. Хүний тоо



Зураг. Олгосон тэтгэвэр, тэтгэмж /сая. төг/






## 1.6 Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр 2019 оны эхний 9 сарын байдлаар 439 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 164 хүн гэмтэж, 27 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 43 (10.9%)-аар, гэмтсэн хүний тоо 70 (74.5%) -аар, нас барсан хүний тоо 11 (68.7%)-ээр нэмэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 12 (6.9%)-аар, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 6 (15.0%)-аар, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 4 (50.0%)-өөр, нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 8 (61.5%)-аар, олон нийтийн аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 14 (87.5%)-өөр тус тус буурч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг бүртгэгдээгүй, бусад төрлийн гэмт хэрэг нэмэгджээ.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сараар




Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 36.9 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 30.8 хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 7.7 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 6.8 хувийг улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг, 4.6 хувийг хүний амины гэмт хэрэг, 3.6 хувийг хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 9.6 хувийг бусад төрлийн гэмт хэргүүд эзэлж байна. Сogтуугаар үйлдсэн гэмт хэрэг 141 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 83 (2.4 дахин)-оор нэмэгдсэн байна.

Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Иххэт, Хатанбулаг, Эрдэнэ, Сайншанд, Замын-Үүд сумдад нэмэгдэж, Дэлгэрэх суманд өмнө онтой адил, бусад сумдад гэмт хэргийн тоо буурсан байна.




Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар



Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 2895.2 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2187.1 (4.1 дахин) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Учирсан хохирлын 708.6 (24.5%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 141 (32.1%) нь согтуугаар, 111 (25.3%) нь гэр орон сууцандаа, 57 (13.0%) нь гудамж олон нийтийн газарт, 14 (3.2%) бүлэглэн, 50(11.4%) хувийг эмэгтэй хүн, хүүхэд оролцон, 136 (31.0%) нь шөнийн цагаар /22-06 цаг/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 1154 хүн саатуулагдаж, 212 хүн баривчлагджээ.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэрэг үйлдэгдсэн цагаар 2019 оны 09 сард




## Хоёр. Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт




### 2.1 Мөнгө, банк

Монгол банкны мэдээгээр арилжааны банкуудын зээлдэгчийн тоо 32.0 мянга болж өмнөх оноос 2.7(8.4%) мянган хүнээр нэмэгдэж, нийт хадгаламж эзэмшигчийн тоо 72.0 мянга болж өмнөх оны мөн үеээс 3.7 хувиар өссөн байна.

Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2018- 2019 он, мян.хүн



Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2018-2019 он, сая.төг




Иргэдийн мөнгөн хадгаламж 113.9 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчид дунджаар 1582.6 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дундажаар 1637.0 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Хадгаламжийн үлдэгдэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20.0 (21.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 9 дүгээр сарын эцэст 5.2 тэр бум төгрөг болж, өмнөх сараас 6.6 (1.2%) тэр бум төгрөгөөр өсч, өмнөх оны мөн үеэс 1.3(33.1%) тэр бум төгрөгөөр өсчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.6 хувийг эзэлж, өмнөх сараас 0.1 пунктээр, өмнөх оны мөн үеэс 0.3 пунктээр тус тус өсчээ.


Чанаргүй зээл 9 дүгээр сарын эцэст 7309.8 сая төгрөг болж өмнөх сараас 147.8(2.1%) сая төгрөгөөр өсч, өмнөх оны мөн үеэс 55.3 (0.8%) сая төгрөгөөр буурсан

байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.6 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 0.3 пунктээр буурсан байна.

Зураг. Зээл төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2019.09 сард




Зураг. Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2019.9 сард



## 2.2 Төсөв, санхүү

2019 оны эхний 09 сарын байдлаар орон нутгийн төсөвт 55116.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 101.5 хувь байна. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 36.3 хувийг татварын, 14.9 хувийг татварын бус орлого, 48.8 хувийг улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлсэн орлого бүрдүүлсэн байна.

Зураг. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүтэц, хувиар, 2019 оны 09-р сард



Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр нийт 6025.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын дүнг өмнөх оны мөн үеэс 2219.3 (58.3%) сая.төг-өөр, төлөвлөгөөнөөс 2623.9 (77.1) сая.төг-өөр давуулан биелүүлсэн байна.



### 2.3 Үнэ


Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2019 оны 09 дүгээр сарыг өмнөх сартай харьцуулахад 0.2 хувь, өмнөх оны мөн үеэс 6.5 хувиар тус тус өсчээ.


**Ерөнхий индекс өмнөх сартай харьцуулахад 0.2 хувиар өсөхөд:** согтууруулах ундаа, тамхины бүлэг 0.4 хувь, хувцас бөс бараа, гутал 0.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 0.6 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 0.4 хувь, бусад бараа үйлчилгээний үнэ 0.5 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

**Ерөнхий индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.5 хувиар өсөхөд:** хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 12.8 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлэг 4.5 хувь, хувцас бөс бараа, гуталын бүлэг 6.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 1.3 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 3.7 хувь, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 3.1 хувь, тээвэрийн бүлэг 1.8 хувь, амралт чөлөөт цаг соёлын барааны бүлэг 3.4 хувь, боловсролын үйлчилгээний бүлэг 9.9 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 9.2 хувь, бусад бараа үйлчилгээний үнэ 6.1 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2019 оны 09 дүгээр сарын өөрчлөлт, бүлгээр, хувиар (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2018-2019 оны үнийн өөрчлөлт, сар бүрээр (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2015-2019 оны 09 дүгээр сар (өмнөх оны 12-р сар=100)



## Гурав. Эдийн засгийн статистикийн үзүүлэлт




### 3.1 Хөдөө аж ахуй

Аймгийн хэмжээнд 2018 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 929.6 мянган хээлтэгч малын 699.1 мянга (75.2%) нь 2019 оны эхний 9 сард төллөсөн байна. Эм хонины 82.2 хувь, эм ямааны 73.2 хувь, ингэний 42.5 хувь, үнээний 57.8 хувь, гүүний 53.5 хувь нь төллөжээ.

Гарсан төлийн 99.6 хувь буюу 701.1 мянган төл бойжиж байна. Бойжуулсан төл өмнөх оны мөн үеэс 101.9 (17.0%) мянгаар нэмэгдсэн байна. Даланжаргалан суманд 73.4 мянга, Дэлгэрэх суманд 72.5 мянга, Айраг суманд 61.7 мянга, Өргөн суманд 57.9 мянга, Иххэт суманд 56.0 мянга, Алтанширээ суманд 53.6 мянга, Хатанбулаг суманд 53.1 мянган төл тус тус бойжсон нь нийт бойжсон төлийн 61.1 хувийг эзэлж байна.

Том малын зүй бус хорогдол 2019 оны эхний 9 сард аймгийн хэмжээнд 4540 болж, өмнөх оны мөн үеэс 5751 (55.9%) толгойгоор буурав. Нийт хорогдсон малын 56.9 хувийг ямаа, 36.3 хувийг хонь эзэлж байна.

*Зураг. Том малын зүй бусын хорогдол, жил бүрийн 09-р сард*



Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн судалгаагаар Сайншанд суманд 09-р сард адууны шир үнэ 9000, үхрийн шир 7000 төгрөг болж өмнөх оноос адууны ширний үнэ 50.0 хувь, үхрийн ширний үнэ 16.7 хувиар нэмэгдсэн байна.

Малын зах зээлийн дундаж үнийн мэдээгээр нас гүйцсэн ат Эрдэнэ суманд хамгийн их буюу 1600.0 мянган төгрөг, Иххэт суманд хамгийн бага буюу 700.0 мянган төгрөг, соёолон үрээ Мандах, Өргөн сумдад их буюу 1100.0 мянган төгрөг, Сайхандулаан суманд хамгийн бага буюу 700.0 мянган төгрөг, хязаалан шар Өргөн суманд хамгийн их буюу 2000.0 мянган төгрөг, Дэлгэрэх, Хөвсгөл сумдад хамгийн бага буюу 900.0 мянган төгрөг байна. Нас гүйцсэн эр хонины дундаж үнэ Эрдэнэ, Замын-Үүд сумдад хамгийн их буюу 200.0 мянган төгрөг, Иххэт суманд хамгийн бага буюу 120.0 мянган төгрөг, нас гүйцсэн эр ямааны дундаж үнэ Хатанбулаг, Хөвсгөл, Эрдэнэ, Замын-Үүд сумдад хамгийн их буюу 150.0 мянган төгрөг, Иххэт суманд хамгийн бага буюу 90.0 мянган төгрөг байна.

9 сарын байдлаар 254.2 тн төмс, хүнсний ногоо хурааснаас төмс 66.9 тн, хүнсний ногоо 187.3 тн хураажээ. Ургац хураалт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад төмс 12.2 тонноор, хүнсний ногоо 5.4 тонноор илүү байна.



### 3.2 Аж үйлдвэр

Оны эхний 09 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарт 158912.3 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 240799.9 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 0.6 хувиар буурч, борлуулалт 4.1 хувиар өссөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 2.9 хувийг төрийн, 97.1 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэжээ.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 2.9 хувь, компани 96.7 хувь, өрхийн аж ахуй 0.4 хувийг тус тус эзэлж байна.

Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дулаан 27.0 мян.ккалаар, ус түгээлт 213.4 мян.м3-аар, сувагжуулалт 144.9 мян.м3-аар, савласан цэвэр ус 408.9 мян.литрээр, талх 14.7 тонноор, нарийн боов 35.3 тонноор, хиам 8.3 тонноор, сүүн бүтээгдэхүүн 11.8 мян.литрээр, хэрчсэн гурил 7.3 мян.тн-оор, банш бууз 3.0 тонноор, бетон зуурмаг 389.7 мян.м3-аар, шохой 13.0 тонноор, цемент 30.4 мян.тонноор, дээл 113 ширхгээр, 1992.9 мян.төгрөгөөр тус тус илүү үйлдвэрлэгджээ.



### 3.3 Тээвэр

2019 оны 9-р сарын байдлаар 142.2 мянган тонн ачаа тээвэрлэж, 41732.9 мянган тонн км-ын ажил, 14.4 мянган зорчигч тээвэрлэж, 4617.0 мянган хүн,км-ын ажил гүйцэтгэсэн байна. Тээвэрлэлтийн нийт орлого 10229.7 сая төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 31.1 хувиар өссөн байна.

## Дөрөв. Байгаль орчны статистикийн үзүүлэлт



### 4.1 Байгаль орчин

#### Цаг уур

2019 оны 09 дугаар сард сарын дундаж агаарын температур: Өргөн, Замын-Үүд, Улаанбадрах, Хөвсгөл сумдад 19.0-20.0 градус, бусад сумдын нутгаар 17.8-18.9 градус дулаан, агаарын хамгийн их температур өдөртөө нийт нутгаар 29-33 градус дулаан байлаа. Агаарын дундаж температурыг олон жилийн дундаж / ОЖД /-тай харьцуулахад: Нийт сумдын нутгаар ОЖД-аас дулаан байлаа. Хөрсний гадарга дээр шөнөдөө 0-4 градус дулаан, өдөртөө нийт сумдын нутгаар 49-56 градус дулаан байв.

Хур тунадас: 9 дүгээр сард нийт нутгаар 1-4 өдөр бороо орж, сарын нийлбэр хамгийн их бороо Иххэт суманд 20.7 мм, хамгийн бага нь Улаанбадрах суманд 0.8 мм, бусад сумдын нутгаар 3.0-16.1 мм бороо орлоо. Орсон хур тунадасны нийлбэрийг олон жилийн дундаж /ОЖД/-тай харьцуулахад: Хөвсгөл суманд ОЖД-



ийн орчим, Мандах, Өргөн, Иххэт сумдад ОЖД-аас ахиу, бусад сумдын нутгаар ОЖД-аас бага байв.

Салхи: Энэ сард салхины хамгийн их хурд Сайншанд, Мандах, Дэлгэрэх сумдад секундэд 15-19 метр хүрч аюултай үзэгдлийн хэмжээнд ажиглагдсан байна. 10 м/с-ээс дээш салхитай 1...19 өдөр байлаа.

Бэлчээрийн ургамал: 9 дүгээр сарын сүүлийн арав хоногийн байдлаар бэлчээрийн ургамлын ургалтын байдал Өргөн сумын зүүн болон өмнө, Дэлгэрэх сумын нутгаар сайн, Сайхандулаан сумын баруун болон өмнө, Замын-Үүд, Улаанбадрах сумдын нутгаар муу, бусад сумдын нутгаар дунд зэрэг байна. Бэлчээрийн ургамлын дундаж өндөр 5-16 см, бэлчээрийн ургац 0.0-0.7 ц/га байна.

МАА-н үйлдвэрлэлд: Цаг агаарын нөхцлөөс болж малын бэлчээрлэлт саатсан тохиолдол гараагүй. Нийт нутгаар отор нүүдэл хийх, хадлан тэжээл бэлтгэх ажил явагдлаа. Малын усан хангамж ихэнх нутгаар хэвийн байлаа.

\_\_\_\_\_ о О о \_\_\_\_\_





**ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**  
( 2019 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН БАЙДЛААР )

**I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд**

	Хэмжих нэгж	2016	2017	2018	2019	2019 2018
1. Бэлэн хүн ам, мян.хүн *	мянган хвн	63.1	68.2	69.6	68.9	99.0
- Төрсөн хүүхдийн тоо**	тоо	1083	954	1037	975	94.0
- Нас барсан хүний тоо - бодит тоогоор**	тоо	263	254	298	290	97.3
- Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор	тоо	820	700	739	685	92.7
- Нялхасын эндэгдэл - бодит тоогоор	тоо	11	9	13	7	2.0 <sup>2</sup>
- 1000 хүүхдэд ноогдох	тоо	10.2	9.4	12.5	7.2	2.1 <sup>2</sup>
2. Ажилгүй иргэдийн тоо - бүгд	тоо	996	1 555	965	470	48.7
- Үүнээс эмэгтэй	тоо	519	785	468	226	48.3
- Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүй иргэдийн тоо	тоо	389	366	236	108	46.0
3. Шинээр бий болсон ажлын байр-бүгд	тоо	286	363	270	131	48.5
Үүнээс: Байнгын ажлын байр	тоо	174	351	142	51	35.9
Улирлын чанартай ажлын байр	тоо	112	12	128	80	62.5
4. Халдварт өвчний гаралт - бодит тоогоор	тоо	1510	566	533	772	144.8
- 10000 хүнд ногдох	тоо	227	83	77	111	144.4
5. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор	тоо	490	534	396	439	110.9
- 10000 хүнд ногдох ***	тоо	115	124	92	99	107.9
6.Бойжиж буй төл	толгой	469517	586705	599281	701158	117.0
- Унага	толгой	12817	21649	21919	24267	110.7
- Тугал	толгой	12753	16615	18153	18366	101.2
- Ботго	толгой	6005	6668	6835	7195	105.3
- Хурга	толгой	236632	286903	294822	345708	117.3
- Ишиг	толгой	201310	254870	257552	305622	118.7
6. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	11011.9	110757.5	159948.5	158912.3	99.4
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая төгрөг	7151.3	175331.9	231302.1	240799.9	104.1

\* - 2016,2017,2018 оны жилийн эцэст

\*\*-Төрөлт, нас баралтыг ЭМГ-ын мэдээнээс авав.

\*\*\* - 18 - аас дээш насны 10000 хүнд ногдохоор тооцов.



## НЭГ. ЭРҮҮЛ МЭНД

## 1.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

	Хэмжих нэгж	2018 I-IX	2019 I-IX	Өсөлт	
		Тоо		Хувь	
1. Амбулаторийн үзлэг	мян.хүн	263.4	300.0	36.6	113.9
2. Ор хоног	мян.хүн	89.9	90.0	0.1	100.1
3. Урьдчилан сэргийлэх тарилга	мян.хүн	8.4	10.5	2.1	125.0
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	12.5	12.6	0.1	100.8
5. Түргэн тусламжын дуудлага	мян.хүн	14.8	14.7	-0.1	99.3
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	2.5	2.5	0	100.0
6. Осол гэмтлийн өвчлөл	хүн	2406	2496	90	103.7
Үүнээс: нас баралт	хүн	76	60	-16	78.9
7. Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх	хүн	1207	1417	210	117.4
Үүнээс: эхний 3 сартайн хяналт	хүн	1062	1260	198	118.6
8. Амаржсан эх	хүн	1034	970	-64	93.8
Үүнээс: нас баралт	хүн	0	0	0	0.0
9. 1-5 хүртэл насны эндсэн хүүхэд	хүн	4	4	0	100.0
10. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	13	7	-6	53.8

## 1.2. ТӨРӨЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар, жил бүрийн 09 сард

Сумын нэр	Амаржсан эх	Эхийн эндэгдэл	Амьд төрсөн хүүхэд	1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд
Дүн	970	0	975	7	2
Айраг	1		1		1
Алтанширээ					
Даланжаргалан	1		1		
Дэлгэрэх					
Иххэт					
Мандах					
Өргөн	2		2		
Сайхандулаан	1				
Улаанбадрах					
Хатанбулаг	3		3	1	
Хөвсгөл	2		2		
Эрдэнэ	2		2		
Сайншанд	766		772	6	1
Замын - Үүд	192		192		

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар



## 1.3. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, төрлөөр, жил бүрийн 09 сард

Үзүүлэлт	2018 I-IX	2019 I-IX	Өсөлт	
	тоо	тоо	тоо	хувь
Халдварт өвчний гаралт-Бүгд	533	772	239	144.8
Вируст гепатит	7	5	-2	71.4
Сүрьеэ	76	67	-9	88.2
Тэмбүү	89	143	54	160.7
Заг хүйтэн	147	229	82	155.8
Трихоминиаз	66	129	63	195.5
Цусан суулга	51	39	-12	76.5
Бусад	97	160	63	164.9

Тайлбар -<sup>2</sup>-дахин их

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар



## ХОЁР. СОЁЛ, БОЛОВСРОЛ

## 2.1 СОЁЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	Хэмжих нэгж	2018 I-IX	2019 I-IX	Өсөлт	
				тоо	хувь
1. Театр -тоглолт	тоо	138	66	-72	47.8
- шинэ уран бүтээл	тоо	4	5	1	0.0
- үзэгчид	мян.хүн	26.9	26.7	-0.2	99.3
- орлого	мян.төг	22 781.5	42 154.6	19 373.1	185.0
- хамрагдсан ААН	тоо	1	1	0.0	0.0
2. Музей					
- үзэгчид	мян. хүн	3.5	2.8	-0.7	80.0
- орлого	мян.төг	4 220.0	4 496.6	276.6	106.6
- хамрагдсан ААН	тоо	2	2	0	0.0

## 2.2 БОЛОВСРОЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	Хэмжих нэгж	2018-2019	2019-2020	Өсөлт	
				тоо	хувь
1. ЕБС-Элсэлт	тоо	3551	3645	94	102.6
Үүнээс: Бага боловсролоор элсэгчид	тоо	1621	1655	34	102.1
Сурагчид	тоо	13009	13971	962	107.4
Үндсэн багш	тоо	629	650	21	103.3
2. МСҮТ - Элсэлт	тоо	516	560	44	108.5
Нийт сурагчид	тоо	693	799	106	115.3
Үндсэн багш	тоо	37	45	8	121.6
Хамрагдсан ААН	тоо	2	2	0	100.0
3. АШУҮИС - Элсэлт	тоо	140	90	-50	64.3
-Анагаах, суурь сургалт /бакалавр/	тоо		23	23	
-Сувилагч /диплом/	тоо		38	38	
-Эх барихуй /бакалавр/	тоо				
-Бусад	тоо	140	29	-111	20.7
Нийт оюутан	тоо	566	470	-96	83.0
Үндсэн багш	тоо	56	51	-5	91.1
4. СӨБ - Элсэлт	тоо	1532	2142	610	139.8
Хамрагдаж байгаа хүүхэд	тоо	5321	5520	199	103.7
Үндсэн багш	тоо	170	187	17	110.0



## ГУРАВ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

## 3.1 БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, боловсролын түвшингээр, жил бүрийн 09 сард

Боловсролын түвшингээр	2016 IX	2017 IX	2018 IX	2019 IX	2019 IX 2016 IX	2019 IX 2018 IX
	хүний тоо				хувь	
ДҮН	996	1 555	965	470	47.2	48.7
Үүнээс: Эмэгтэй	519	785	468	226	43.5	48.3
Магистр, доктор	7	9	2	1	14.3	50.0
Дээд боловсролтой	263	361	161	56	21.3	34.8
Тусгай дунд	107	122	33	10	9.3	30.3
Техник мэргэжлийн	113	144	64	12	10.6	18.8
Бүрэн дунд	362	758	624	349	96.4	55.9
Бүрэн бус дунд	115	123	49	28	24.3	57.1
Бага	21	19	8	2	9.5	3.5 <sup>2</sup>
Боловсролгүй	8	19	24	12	150.0	50.0

## 3.2 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, жил бүрийн 09 сард

	Ажилгүй иргэдийн тоо		Ажилд орсон хүний тоо		Шинээр бүртгүүлсэн хүний тоо	
	2018 IX	2019 IX	2018 I-IX	2019 I-IX	2018 I-IX	2019 I-IX
ДҮН	965	470	443	368	2201	130
Айраг	19	11	31	2	137	1
Алтанширээ	36	2	10	13	93	0
Даланжаргалан	71	26	37	34	135	0
Дэлгэрэх	16	8	4	5	22	0
Иххэт	29	9	29	5	278	0
Мандах	17	7	71	6	105	0
Өргөн	24	11	26	72	107	0
Сайхандулаан	11	5	5	10	677	3
Улаанбадрах	17	10	46	17	39	2
Хатанбулаг	19	9	18	16	94	0
Хөвсгөл	7	7	16	6	62	4
Эрдэнэ	30	33	9	20	30	1
Сайншанд	526	239	98	92	304	117
Замын - Үүд	143	93	43	70	118	2

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



## 3.3 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эдийн засгийн салбарын ангилал, 2019 оны 09 сарын эцэст

Салбарын ангилал	2018 I-IX	2019 I-IX
	Тоо	
Бүгд	539	397
ХАА, ан агнуур, ойн аж ахуй,загас барилт	10	24
Уул уурхай олборлох аж үйлдвэр	194	130
Боловсруулах үйлдвэрлэл	7	1
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	6	4
Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын	9	12
Барилга	61	43
Бөөний ба жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар	1	
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	17	4
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	1	2
Мэдээлэл, холбоо		
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	15	6
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа		
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа		
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	3	
Төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа, албан	57	36
Боловсрол	33	40
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	30	7
Урлаг, үзвэр,тоглоом наадам	11	1
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	83	87
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа,өрхийн		
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл	1	

## 3.4 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил, мэргэжлийн ангилал, 2019 оны 09 сарын эцэст

Үзүүлэлт	2018 I-IX	2019 I-IX
	Тоо	
Бүгд	539	397
Менежер	11	8
Мэргэжилтэн	117	55
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	62	58
Контор, үйлчилгээний ажилтан	19	25
Худалдаа, үйлчилгээний ажилтан	55	22
ХАА, ой загас агнуурын ажилтан	3	15
Үйлдвэрлэл, барилга,гар урлал,холбогдох ажил үйлчилгээний ажилтан	32	30
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	78	42
Энгийн ажил мэргэжил	150	135
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	12	7

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



## 3.5 АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭД, ажил, мэргэжлийн ангиллаар жил бүрийн 09 сард

Үзүүлэлт	2018 I-IX		2019 I-IX	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
	Тоо		Тоо	
Бүгд	443	195	368	159
Менежер	10	7	6	4
Мэргэжилтэн	74	52	54	41
Техникч болон туслах дэд/мэргэжилтэн	45	25	54	25
Контор, үйлчилгээний ажилтан	22	15	23	21
Худалдаа, үйлчилгээний ажилтан	51	39	18	15
ХАА, ой загас агнуурын ажилтан	1		15	5
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил	27	6	29	4
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	62	11	40	1
Энгийн ажил мэргэжил	140	36	123	38
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	11	4	6	5

## 3.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД ОРСОН ИРГЭН, эдийн засгийн салбарын ангиллаар 2019 оны 09 сард

Салбарын ангилал	Бүгд	Эмэгтэй	Бүгдээс: Ажлын байрны шинж, чанараар	
			Байнга	Улирал
	Тоо			
Бүгд	131	27	51	80
ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	41	1	6	35
Уул уурхай олборлолт	1		1	
Боловсруулах үйлдвэрлэл	1	1	1	
Цахилгаан, хий уур агааржуулалтын хангамж				
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент				
Барилга	30		2	28
Бөөний ба жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	4	1	3	1
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	3	2	3	
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	12	1	1	11
Мэдээлэл холбоо				
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1	1	1	
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа				
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл	25	15	24	1
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа				
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал	6	1	3	3
Боловсрол	7	4	6	1
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа				
Урлаг үзвэр тоглоом наадам				
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа				
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй				
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа				

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



## ДӨРӨВ. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

## 4.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн 09 сард

Үзүүлэлт	2018 I-IX	2019 I-IX	2019 I-IX 2018 I-IX
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	23 799.1	30 579.7	128.5
Тэтгэврийн даатгалын сан	14974.4	19 315.7	129.0
Тэтгэмжийн даатгалын сан	1697.8	2 189.0	128.9
Эрүүл мэндийн даатгалын сан	3956.5	4 992.2	126.2
ҮОМШӨ*-ний даатгалын сан	2482.2	3 197.7	128.8
Ажилгүйдлийн даатгалын сан	688.2	885.1	128.6
Нийгмийн даатгалын сангийн зарлага	33 303.7	37 807.1	113.5
Тэтгэврийн даатгалын сан	24203.9	27 992.6	115.7
Тэтгэмжийн даатгалын сан	1873.7	2 268.1	121.0
Эрүүл мэндийн даатгалын сан	4 809.7	4 482.1	93.2
ҮОМШӨ*-ний даатгалын сан	1813.4	2 240.2	123.5
Ажилгүйдлийн даатгалын сан	603.0	824.1	136.7

## 4.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 09 сард

Үзүүлэлт	2018 I-IX	2019 I-IX	2019 I-IX 2018 I-IX
	хүн		хувь
1. Нийгмийн даатгалд даатгуулагчид	20 845.0	21 575.0	103.5
Албан журмаар даатгуулагчид	17 009.0	17 661.0	103.8
Аж ахуй нэгж, байгууллага	8 740.0	9 179.0	105.0
Төсөвт байгууллага	8 269.0	8 482.0	102.6
Сайн дураар даатгуулагчид	3 836.0	3 914.0	102.0
2. Тэтгэвэр авагчдын тоо	8 187.0	8 689.0	106.1
Өндөр насны тэтгэвэр	6233	6 226.0	99.9
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	1308	1 307.0	99.9
20 Тэжээгчээ алдсаны	504	504.0	100.0
Цэргийн тэтгэвэр	460	456.0	99.1
ҮОМШӨ*-ний	158	196.0	124.1
	сая төгрөг		
3. Олгосон тэтгэвэр	24 818.2	28 533.9	115.0
Өндөр насны тэтгэвэр	18017.4	20 671.9	114.7
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	2807.1	3 299.0	117.5
Тэжээгчээ алдсаны	1232.1	1 340.0	108.8
Цэргийн тэтгэвэр	2110.2	2 577.1	122.1
ҮОМШӨ*-ний	651.4	645.9	99.2

Тайлбар: \*-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин  
Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс





## 4.3 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сумаар

Сумын нэр	2018 I-IX	2019 I-IX	2019 I-IX 2018 I-IX
	сая төгрөг		хувь
ДҮН	23799.1	30579.7	128.5
Айраг	415.5	535.4	128.9
Алтанширээ	143.2	189.9	132.6
Даланжаргалан	1104.2	1319.3	119.5
Дэлгэрэх	172.6	219.4	127.1
Иххэт	220.4	396.1	179.7
Мандах	285.4	248.8	87.2
Өргөн	618.8	1102.9	178.2
Сайхандулаан	181.6	254.6	140.2
Улаанбадрах	178.1	238.2	133.7
Хатанбулаг	415	529.1	127.5
Хөвсгөл	182.9	230.8	126.2
Эрдэнэ	327.6	443.5	135.4
Сайншанд	13438.2	17289.6	128.7
Зүүнбаян баг	719.9	751.5	104.4
Замын-Үүд	5395.7	6830.6	126.6

## 4.4 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, сумаар

Сумын нэр	2018 I-IX	2019 I-IX	2019 I-IX 2018 I-IX
	сая төгрөг		хувь
ДҮН	33303.7	37807.1	113.5
Айраг	1661.7	1859.8	111.9
Алтанширээ	643.1	706.9	109.9
Даланжаргалан	1365	1674.8	122.7
Дэлгэрэх	673	778.8	115.7
Иххэт	1203.2	1351.3	112.3
Мандах	747.7	793.5	106.1
Өргөн	1214.7	1462.4	120.4
Сайхандулаан	475.8	545.9	114.7
Улаанбадрах	724.5	842.3	116.3
Хатанбулаг	1273.9	1464.4	115.0
Хөвсгөл	625	686.9	109.9
Эрдэнэ	1100.3	1273	115.7
Сайншанд	14238.5	15802.3	111.0
Зүүнбаян баг	1280.5	1380.9	107.8
Замын-Үүд	6076.8	7183.9	118.2



## 4.5 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 09 сарын эцэст

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2019 I-IX	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2019 I-IX
	2018 I-IX	2019 I-IX	2018 I-IX	2018 I-IX	2019 I-IX	2018 I-IX
	тоо		хувь	сая төгрөг		хувь
<b>НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ</b>	<b>22998</b>	<b>24218</b>	<b>105.3</b>	<b>6070.0</b>	<b>6327.8</b>	<b>104.2</b>
<b>1. Халамжийн тэтгэвэр</b>	<b>1362</b>	<b>1394</b>	<b>102.3</b>	<b>1703.3</b>	<b>1920.8</b>	<b>112.8</b>
Ахмад настны тэтгэвэр	60	82	136.7	75.1	105.4	140.3
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	1302	1312	100.8	1628.2	1815.4	111.5
<b>2 Нөхцөлт мөнгөн тэтгэмж</b>	<b>1069</b>	<b>1063</b>	<b>99.4</b>	<b>568.9</b>	<b>625.5</b>	<b>109.9</b>
Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэнд олгосон тэтгэмж	1006	1003	99.7	532.2	588.2	20.5
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгазан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	51	51	100.0	30.2	31.8	105.3
Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг мөн хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	6	7	116.7	4.3	4.2	97.7
Ахмад настаныг гэртээ асрамжилж байгаа иргэн	5	2	40.0	1.6	1.3	81.3
Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн	1			0.6	0.0	0.0
<b>3. Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн дүн</b>	<b>996</b>	<b>963</b>	<b>96.7</b>	<b>466.1</b>	<b>452.0</b>	<b>97.0</b>
16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	234	227	97.0	287.9	294.3	102.2
Байнгын асаргаа шаардлагатай 16-с дээш насны иргэн	711	685	96.3	112.2	88.9	79.2
Гурав ба түүнээс дээш тооны бага насны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/	4	0		0.4	0.0	
2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж	10	7	70.0	20.0	14.0	70.0



## Хүснэгт 4.5-ийн үргэлжлэл

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2019 I-VI 2018 I-VI	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2019 I-VI 2018 I-VI
	2018 I-VI	2019 I-VI		2018 I-VI	2019 I-VI	
	тоо		хувь	мянган төгрөг		хувь
18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	11	6	54.5	13.2	9.2	69.7
Гэнэтийн аюул, ослын улмаас орон гэргүй болсон өрх	14	34	242.9	18.0	40.8	226.7
Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн	12	1	8.3	14.4	1.2	8.3
Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай, 4 ба түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон иргэн	0	3		0.0	3.6	
<b>4. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардал</b>	<b>0</b>	<b>0</b>		<b>0</b>	<b>0</b>	
<b>5. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах зардал</b>	<b>8386</b>	<b>9284</b>	<b>110.7</b>	<b>823.1</b>	<b>813.6</b>	<b>98.8</b>
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт	3847	3860	100.3	265.2	227.7	85.9
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	286	197	68.9	74.1	77.2	104.2
Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүн, сум, хорооны нийгмийн ажилтанд олгох урамшил	0	0	0.0	5.1	0.7	13.7
Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт	2896	3822	132.0	289.1	329.0	113.8
Банкны шимтгэл				3.0	3.3	110.0
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийн зарцуулалт	1357	1405	103.5	186.6	175.7	94.2
